

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянтал сумын Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/02/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Дарханбат Утас: 70543179 Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГСА-2022/02/СТА-ТТЗ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУБ	Олон улсын байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. Аудитын гэрчилгээ



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govिसumber@audit.gov.mn

Говьсүмбэр аймгийн Засаг дарга, Говьсүмбэр сум, 3 дугаар баг
№ 56
танай _____ -ны № _____ -т

БЯЯНТАЛ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Г.АНХБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Баянтал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

018020172

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		613,261.90	700,492.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	129,478.80	107,997.10
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	181,453.80	320,016.70
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	4,510.00	4,360.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	279,299.90	249,537.60
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	13,719.40	13,781.50
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	4,800.00	4,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,082,030.60	4,004,961.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,082,030.60	4,004,961.00
39100	Газар		0	0
39200	Биет хөрөнгө		3,988,852.40	3,912,582.40
39300	Биет бус хөрөнгө	13	93,178.30	92,378.70
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,695,292.60	4,705,453.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		13,739.50	9,987.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	13,739.50	9,987.10
41300	Өглөг	17а, 17б	13,739.50	9,987.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,681,553.10	4,695,466.80
51	Засгийн газрын хувь оролцоо		4,681,553.10	4,695,466.80
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,917,649.50	1,917,649.50
51200	Хуримтлагдсан үр дүн		450,081.60	463,995.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,313,822.00	2,313,822.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,695,292.60	4,705,453.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,861,340.40	2,251,905.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО		33,763.70	57,663.30
110	Орлогын албан татвар		21,013.20	22,176.50
1100	Хувь хүний орлогын албан татвар		21,013.20	22,176.50
113	Хөрөнгийн албан татвар		660	19,809.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж		12,090.50	15,677.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	414,363.10	252,904.70
120	Нийтлэг татварын бус орлого		414,363.10	252,904.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,413,213.70	1,941,337.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,874,149.00	2,159,353.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,874,149.00	2,159,353.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,000,983.60	2,103,200.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		936,830.00	1,052,972.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		117,271.90	139,404.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		275,942.80	309,707.60
2104	Хангамж, бараа материалын зардал		352,905.60	153,390.70
2105	Нормативт зардал		61,947.10	130,762.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,255.70	34,619.90
2107	Томилолт, зочны зардал		3,406.00	6,665.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		9,273.60	6,912.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		239,151.00	268,764.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		873,165.40	56,152.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-12,808.60	92,552.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		0	85,005.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-12,808.60	7,546.40

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,698,680.40	0	4,698,680.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,318.80	0	-4,318.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,694,361.70	0	4,694,361.70
4	Тайлант үеийн үр дүн	-12,808.60	0	-12,808.60
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,681,553.10	0	4,681,553.10
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,681,553.10	0	4,681,553.10
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,367.30	0	6,367.30
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,687,920.40	0	4,687,920.40
9	Тайлант үеийн үр дүн	7,546.40	0	7,546.40
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,695,466.80	0	4,695,466.80

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		2,521,159.4	1,939,202.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		33,763.7	57,663.3
110	Орлогын албан татвар		21,013.2	22,176.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		21,013.2	22,176.5
113	Хөрөнгийн албан татвар		660.0	19,809.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж		12,090.5	15,677.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		8,589.7	10,166.7
1181	Газрын төлбөр		3,500.8	5,510.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		64,236.9	72,267.1
120	Нийтлэг татварын бус орлого		64,236.9	72,267.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,423,158.9	1,809,272.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,426,983.9	1,785,085.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,426,983.9	1,785,085.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,552,917.2	1,725,672.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		942,048.3	1,055,155.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		116,961.1	133,910.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		276,169.0	309,602.3
2104	Хангамж, бараа материалын зардал		57,405.3	51,580.3
2105	Нормативт зардал		52,386.4	47,371.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		22,065.9	45,614.5
2107	Томилолт, зочны зардал		3,406.0	6,665.4

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		19,256.9	28,543.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		63,218.2	47,228.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		874,066.8	59,413.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		94,175.5	154,117.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		105,720.0	99,928.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		105,720.0	99,928.9
2200	Дотоод эх үүсвэрээр		105,720.0	99,928.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-105,720.0	-99,928.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-1,398.0	-75,670.0
14	Бусад эх үүсвэр		0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		1,398.0	75,670.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-12,942.5	-21,481.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		142,421.3	129,478.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		129,478.8	107,997.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,882,352.30	1,813,744.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,697,795.10	1,670,625.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,669,552.40	1,643,624.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,043,709.50	1,038,804.55
210101	Үндсэн цалин	753,525.00	662,275.71
210102	Нэмэгдэл	221,081.40	317,541.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,077.40	12,251.95
210104	Урамшуулал	55,025.70	46,735.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,445.40	132,238.40
210201	Тэтгэврийн даатгал	109,762.40	110,050.07
210202	Тэтгэмжийн даатгал	6,422.70	6,397.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,146.00	4,684.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,294.30	1,044.47
210205	Эрүүл мэндийн даатгал	12,820.00	10,062.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	311,546.50	309,549.92
210301	Гэрэл, цахилгаан	16,100.00	11,532.96
210302	Түлш, халаалт	275,746.50	277,177.44
210303	Цэвэр, бохир ус	19,700.00	20,839.52
2104	Хангамж, бараа материалын зардал	31,902.20	31,902.20
210401	Бичиг хэрэг	5,840.50	7,323.75
210402	Тээвэр, шатахуун	17,402.90	14,581.67
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,745.90	5,075.85
210404	Ном, хэвлэл	131.80	84.30

Баянтал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	815.10	720.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,966.00	4,116.63
2105	Нормативт зардал	36,343.60	25,925.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,714.60	10,639.27
210502	Хоол, хүнс	21,724.60	14,531.59
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	904.40	754.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,989.70	51,606.68
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,710.00	16,709.70
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.40	943.20
210604	Урсгал засвар	35,336.30	33,953.78
2107	Томилолт, зочны зардал	5,813.90	6,665.42
210702	Дотоод албан томилолт	5,813.90	6,665.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,181.90	9,681.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,678.30	6,653.89
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.00	1,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,282.00	210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	314.10	220.63
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	244.50	44.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,540.00	1,440.00
210807	Газрын төлбөр	123.00	113.12
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,619.70	37,250.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,601.10	35,231.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,018.60	2,018.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,242.70	27,001.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,500.00	7,500.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	7,500.00	7,500.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,742.70	19,501.56
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,870.30	12,716.35
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,872.40	6,785.22
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,231.50	67,448.92
223001	Бусад хөрөнгө	70,231.50	67,448.92
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	114,325.70	75,670.00
230001	Эргэж төлөгдөх зээл	114,325.70	75,670.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,882,352.30	1,793,475.15
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	919,167.30	909,662.48
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	868,744.70	859,239.88
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	50,422.60	50,422.60
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	804,362.00	798,094.05
320001	Орон нутгийн төсвөөс	804,362.00	798,094.05
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	19,799.10	13,451.48
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,799.10	13,451.48
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	139,023.90	72,267.14
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000.00	61,018.52

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000.00	11,248.62
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	89,023.90	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	89,023.99
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	68,754.44
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	371	390
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7	7
610001	Төсвийн байгууллага	7	7
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	64	67
620001	Удирдах ажилтан	10	10
620002	Гүйцэтгэх ажилтан	34	34
620003	Үйлчлэх ажилтан	19	22
620004	Гэрээт ажилтан	1	1
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	236	249
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	134	147
630001	Төрийн өмчит ЕБС	134	147
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	102	102
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	102	102
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	64	67
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	24	27
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21	21
650010	Гэрээт ажилтан	1	1
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	130,360.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	127,010.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103,475.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,351.10
210101	Үндсэн цалин	16,179.99
210102	Нэмэгдэл	171.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,672.33
210201	Тэтгэврийн даатгал	1,672.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52.36
210302	Түлш, халаалт	52.36
2104	Хангамж, бараа материалын зардал	19,725.00
210401	Бичиг хэрэг	2,290.00
210402	Тээвэр, шатахуун	14,815.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,080.00
2105	Нормативт зардал	21,446.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,308.94
210502	Хоол, хүнс	5,137.62
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,957.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,299.90

Баянтал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	9,657.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,862.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,648.13
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34.00
210807	Газрын төлбөр	179.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,409.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,409.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,534.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,513.60
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,113.60
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,350.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,350.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,350.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	131,172.86
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131,172.86
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,588.56
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,122.80
131106	Хаагдсан данс	-
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	66,461.50
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	812.49
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	812.49

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянтал сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-наас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлсэн.

Баянтал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 87 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянтал сумын “Засаг дарга”-ын үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх.” гэж тодорхойлсон бөгөөд Аймгийн Засаг даргаас гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 83.6 хувьтай гэж үнэлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-аас 2021 оны 6 дугаар сарын 11-нд батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянтал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2,042.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 30.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 21.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Баянтал сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данснудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 129.5 сая, эцсийн үлдэгдэл 108.0 сая төгрөг болж, 21.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөг/ Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	129.48	107.99	-21.49	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж			-	-
Дүн	129.48	108.00	(21.49)	100.00

Эх сурвалж: Баянтал сумын "Засаг дарга"-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 108.0 сая сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Хадгаламж дансанд эхний, эцсийн үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил илрээгүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 181.5 сая, эцсийн үлдэгдэл 320.0 сая төгрөг болж, 138.6 сая нэмэгдсэн байна. Авлага дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй байна

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.80	1.57	(0.23)
Төлбөртэй үйлчилгээний авлага		133.77	133.77
Татаас, санхүүжилтийн авлага			-
Зээлийн хүүгийн авлага	0.02		(0.02)
Бусад авлага	179.63	184.67	5.04
Зээлийн авлага			-
Дүн	181.45	320.02	138.56

Эх сурвалж: Баянтал сумын “Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангийн үндсэн болон зээлийн хүүгийн авлага 153.6 сая, хувь хүнээс авах авлага 19.5 сая, эрүүл мэндийн төвийн ковидын санхүүжилтийн авлага 133.7 сая, ажиллагсадтай холбоотой 1.6 сая, орон нутгийн хөгжлийн сангийн урьдчилгаа 9.5 сая, бусад авлага 2.1 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 175.2 сая төгрөгийн дараах авлагатай байна. Үүнд

Баянтал сумын эрүүл мэндийн төв 5.6 сая, 4 дүгээр сургууль 14.9 сая, 4 дүгээр цэцэрлэг 3.4 сая, ЗДТГ 3.6 сая, Орон нутгийн хөгжлийн 9.5 сая төгрөг нийт 37.0 сая төгрөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй бүртгэсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага 153.6 сая төгрөг бөгөөд тайлант онд 75.0 сая төгрөгийн зээл олголт хийж хугацаа хэтэрсэн зээлдэгчдийг шүүхэд шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын бүртгэл тайлагналтай холбоотой 9.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 1.6 сая төгрөгийн 1 алдаа залруулж, 7.4 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 4.5 сая, эцсийн үлдэгдэл 4.4 сая төгрөг болж, 0.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	4.5	4.4	-0.1
Дүн	4.5	4.4	-0.1

Эх сурвалж: Баянтал сумын “Засаг дарга”-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цалингийн урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэлд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй Баянтал сумын ЭМТ-н 4.0 сая, 4 дүгээр цэцэрлэгийн 0.2 сая, ЗДТГ-ын 0.2 сая, нийт 4.4 сая төгрөгийн олон жилийн насжилттай урьдчилгааны авлага бүртгэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт: Цалингийн урьдчилгаа данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 297.8 сая, эцсийн үлдэгдэл 268.1 сая төгрөг болж, 29.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	68.21	52.46	(15.74)
Эм боох материал	22.29	16.86	(5.43)

Бичиг хэргийн материал	2.19	1.56	(0.63)
Аж ахуйн материал	40.53	35.04	(5.49)
Сэлбэг хэрэгсэл			-
Түлш, шатах тослох материал	3.71	0.37	(3.33)
Барилгын засварын материал	2.30	0.93	(1.37)
Хүнсний материал	4.79	4.08	(0.71)
Бусад хангамжийн материал	135.28	138.24	2.95
Тэжээлийн нөөц	13.72	13.78	0.06
Бусад эргэлтийн хөрөнгө	4.80	4.80	-
Дүн	297.82	268.12	(29.70)

Эх сурвалж: Баянтал сумын "Засаг дарга"-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд нөөцөлсөн болон ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал илрээгүй.

Бараа материалын данс нь худалдан авсан 177.3 сая, иргэдийн хандиваар 0.4 сая, шилжүүлэн авсан 1.1 сая, улсын болон орон нутгийн төсөв, аймаг сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 93.8 сая, нийт 272.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 271.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, байгууллагын даргын тушаалаар акталж данснаас хассан 30.6 сая, нийт 302.4 сая төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянтал сумын ИТХ нь бараа материалыг дансны ангиллын дагуу бүртгээгүй, 1.9 сая төгрөгийн хангамжийн материалыг тусгай зориулалтын материалын дансанд бүртгэсэн тул алдаа, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.
- Баянтал сумын Соёлын төв нь нярвын тайланд 204.8 мянган төгрөгийн бараа материалыг орлого, зарлагаар илүү бүртгэсэн.
- Баянтал сумын ЭМТ нь завсрын болон өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. Санхүүгийн ажилтнууд 4 удаа солигдсоноос үндсэн хөрөнгө, бараа материалын тайланд хяналт тавьж баталгаажуулаагүй, ажил гүйлгээг гарсан тухай бүрд хөдөлгөөнийг бүртгээгүй, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж тайлагнасан. Бараа материалын тайлангийн эхний үлдэгдэл 2,722.4 мянга, орлого 7,273.6 мянга, зарлага 5,196.7 мянга, үлдэгдэл 4,799.7 мянга, нийт 19,992.8 мянган төгрөгөөр зөрүүтэй, байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 2,705.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан тул алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 22.7 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.
- Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг нь бараа материалын тайланг хөдөлгөөн гараагүй сард тайлан гаргаагүй /Бичиг хэргийн тайлан, Аж ахуйн материалын тайлан 2-6 сар, Хүнсний тайлан 4-6 сарууд/, 1 жилээс дээш ашиглагдах хөрөнгүүдийг бусад хангамж материал дансанд бүртгээгүй зөрчил илэрч аудитын явцад залруулсан байна. Мөн ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин ажлын хувцас худалдан авалт хийсэн. Мөн байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй бөгөөд халаалтын зардлыг 13%-иар нэмээгдүүлсэн тул 2.9 сая төгрөгийн албан шаардлага өгсөн байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,082.0 сая, эцсийн үлдэгдэл 4,004.9 сая төгрөг болж, 77.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	3,390.56	3,301.30	(89.26)
Тээврийн хэрэгсэл	72.23	64.55	(7.68)
Машин тоног төхөөрөмж	95.18	162.37	67.19
Тавилга эд хогшил	99.94	100.06	0.12
Номын фонд	39.28	41.78	2.50
Бусад үндсэн хөрөнгө	279.16	229.57	(49.59)

Дуусаагүй барилга, байгууламж	10.00	10.00	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2.50	2.97	0.47
Программ хангамж	1.62	0.82	(0.80)
Бусад биет бус хөрөнгө	91.56	91.56	-
Дүн	4,082.02	4,004.97	-77.05

Эх сурвалж: Баянтал сумын "Засаг дарга"-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 24.8 сая, балансас баланст шилжүүлэн авсан 9.9 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1.3 сая, улс, орон нутгийн төсөв, аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 112.4 сая, нийт 148.4 сая төгрөгөөр нэмэгдэж, акталсан үндсэн хөрөнгө 225.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга, бусад биет бус хөрөнгийн дансанд өөрчлөлт гараагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянтал сумын ИТХ, Соёлын төв, 4 дүгээр цэцэрлэг, 4 дүгээр сургууль нь ашиглалтын хугацаа дууссан 23.2 сая төгрөгийн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй.
- Баянтал сумын ЗДТГ, 4 дүгээр цэцэрлэг үндсэн хөрөнгийн элэгдлийг 10.4 сая төгрөгөөр илүү дутуу тооцсон.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 9.9 сая төгрөг болж, өмнөх оноос 3.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	0.80	2.66	1.86
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2.77	2.77	(0.00)
Байгууллагад төлөх өглөг	8.91	2.84	(6.07)
Хувь хүмүүст төлөх өглөг	1.25	1.71	0.46
Бусад урьдчилж орсон орлого			-
Дүн	13.74	9.99	(3.75)

Эх сурвалж: Баянтал сумын "Засаг дарга"-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажиллагсадтай холбоотой өглөг дансны үлдэгдэлд Баянтал сумын ЭМТ-ийн нийгмийн даатгал, хувь хүний орлогын татварын өр 2.7 сая, бараа ажил үйлчилгээний өглөг дансанд 4 дүгээр цэцэрлэгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 2.5 сая, эрүүл мэндийн төвийн эмийн өр 0.2 сая, байгууллагад төлөх өглөг дансны үлдэгдэлд орон нутгийн хөгжлийн сангийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 1.2 сая, ЗДТГ-ын өвсний үнэ 1.3 сая, эрүүл мэндийн төвийн 0.3 сая, хувь хүн хүмүүст төлөх өглөг дансанд 4 дүгээр цэцэрлэгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 1.2 сая, эрүүл мэндийн төвийн 0.5 сая, нийт 9.9 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Нийт өр төлбөрөөс 3.7 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч нь байхгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянтал сумын ЗДТГ хагас жилийн санхүүгийн тайланд өр төлбөрийг нэмэгдүүлж үүсгэсэн байсныг жилийн эцэст залруулсан.
- Баянтал сумын ЭМТ санхүүгийн тайланд 3.0 төгрөгийн өр төлбөрийн илүү үүсгэсэн мөн завсрын аудит болон өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. Жилийн эцсийн санхүүгийн тайланд өр төлбөрийг нэмэгдүүлж үүсгэсэн тул 3.7 сая төгрөгийн албан шаардлага өгсөн

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,695.5 сая төгрөг болж, өмнөх оноос 13.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	1,917.65	1,917.65	-
Хуримтлагдсан үр дүн	450.08	464.00	13.91
Өмнөх үеийн үр дүн	462.89	456.45	(6.44)
Тайлант үеийн үр дүн	(12.81)	7.55	20.36
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,313.82	2,313.82	-
Дүн	4,681.55	4,695.47	13.91

Эх сурвалж: Баянтал сумын "Засаг дарга"-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүн 7.5 сая, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 6.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд Баянтал сумын ЗДТГ-ын илүү тооцсон элэгдлийн зардал 8.3 сая, 4 дүгээр цэцэрлэг үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу 1.4 сая, 4 дүгээр сургууль 0.6 сая төгрөгийн залруулга хийсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны төсвийн төслийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,614.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 10, 2021 оны 08, аймгийн ИТХ-ын 05 дугаар тогтоолоор төсөв захирагчийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,882.4 сая төгрөгөөр баталж, 267.8 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг татварын орлогоос 26.0 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 867.7 сая, аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 746.1 сая, ОНХС-гийн орлогын шилжүүлэг 50.4 сая, ЭМД-н санхүүжилт 19.8 сая, орон нутгийн 2020 оны тэнцлийн ашгаас 32.3 сая, сумын ОНХС-гийн үлдэгдэл 24.7 сая, сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн эргэлт төлөлтөөс 114.3 сая нийт 1,882.3 сая төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 859.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 50.4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 798.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 13.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 72.3 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, эхний үлдэгдлээс 20.3 сая, нийт 1,813.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 72.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 22.2 сая төгрөгөөр давсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, авлагын барагдуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран ажиллаж нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

Хүснэгт 8. Үйл ажиллагааны орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	45.00	61.02	16.02	71.9

Туслах үйл ажиллагааны орлого	5.00	11.25	6.25	28.1
Нийт дүн	50.00	72.27	22.27	100

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,813.7 сая төгрөг буюу 96.0 хувьтай байгаа нь цалин НДШ-ийн зардал 29.1 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2.0 сая, нормативд зардал 10.4 сая, эд хогшил, урсгал засварын зардал 1.4 сая, бараа үйлчилгээний бусад зардал 3.3 сая, хөрөнгийн зардал 2.7 сая, сум хөгжүүлэх сангийн хэмнэлт 38.6 сая төгрөгийн хэмнэлт үүссэнтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 15.8 сая төгрөгийг төвлөрүүлснээс орон нутгийн төсөвт 6.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламж болон гадаад төсөл хөтөлбөрөөс санхүүжилт аваагүй байна. Харин дээд шатны төсвийн захирагчаас 35.6 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 29.1 сая, эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлого 66.4 сая, нийт 131.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 127.0 сая, хөрөнгийн зардалд 3.3 сая, нийт 130.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.9 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл Баянтал сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 8 үзүүлэлтийн зорилтот түвшинд баталснаас гүйцэтгэлээр 83.6 хувийн биелэлттэй байна.

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108, 111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцолсон.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд Баянтал сумын Засаг дарга санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурьд өөрчлөлт оруулаагүй байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баянтал сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд нийт 155 мэдээлэл байршуулахаас 155 мэдээллийг ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 101.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 101.8 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмжийг өгсөн байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Баянтал сумын Засаг даргын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт.9 Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1.3	1	1.3	0	0	0
Албан шаардлага							
Зөвлөмж	2	0	2	0	0	0	0
Нийт дүн	3	1.3	1	1.3	0	0	0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 429.4 сая төгрөгийн 58 алдаа, зөрчил илэрснээс, 142.3 сая төгрөгийн 24 алдааг залруулж, 3.5 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 273.3 сая төгрөгийн 18 албан шаардлага хүргүүлж, 10.3 төгрөгийн алдаа зөрчилд 9 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 10.3 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 30.6 сая төгрөгөөс бага тул “Зөрчилгүй” санал дүгнэлт дүгнэлт өгсөн.

4.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсвийн байгууллага, сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4, “Хязгаарлалттай” 2 дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 330.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 90.2 сая төгрөгийн 22 алдааг аудитын явцад залруулж, 3.6 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 226.3 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 10.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг хүргүүлжээ.

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 99.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 52.2 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 46.9 сая төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

4.2.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

1. Баянтал сумын 4 дүгээр сургуулийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдсан алдаа, зөрчлийг залруулж нэгтгээгүй, үндсэн хөрөнгийн тодруулгыг 52.2 сая төгрөгийн зөрүүтэй нэгтгэсэн зөрчлийг аудитын явцад залруулсан

4.2.2 Албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 46.9 сая төгрөгийн 1 арилгах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Санхүүгийн тайланд тусгагдсан хугацаа хэтэрсэн 46.9 сая авлага, өр төлбөрийг барагдуулаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 15 дугаар зүйлийн 15.4.1 дах заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.2.3.Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлт						Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								
			Үүнээс								Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
			Бүгд	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Түүвэрт хамруулсан	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо
1	Баянтал сумын Засаг дарга	ГСА-2022/02/СТА-ТТЗ	1	1				3	52.2	2	52.2			1					
ДҮН			1	1				3	52.2	2	52.2			1					1

5.2 Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс														
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж						
			тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн					
1	Баянтал сумын Засаг дарга	ГСА-2022/02/СТА-ТТЗ																	

5.3 Харьяа байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Зөрчлийн дүн	Шийдвэрлэсэн байдал /сая төгрөгөөр/											
			Залруулсан		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийцлийн аудит / Албан шаардлага/		Нийцлийн аудит / Зөвлөмж/	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянтал сумын ИТХ	5.0		-		-	1	3.1	2	1.9		-		-
2	Баянтал сумын ЗДТГ	17.1	5	12.7	1.0	0.2	2	4.0	1	0.2		-		
3	Баянтал сумын ОНХС	11.4		-		-	1	11.4		-		-	1	
4	Баянтал сумын Соёлын төв	9.6	1	0.2		-	2	9.4	1	-		-		
5	Баянтал ЭМТөв	115.1	4	6.4	1.0	0.2	5	33.6	1	1.0	1	73.9		
6	Баянтал сумын 4-р цэцэрлэг	55.5	8	12.3	5.0	3.2	3	4.9	2	7.2	1	28.0		
7	Баянтал сумын 4-р сургууль	110.2	2	52.2		-	1	58.0		-		-		
8	Баянтал сумын Сум хөгжүүлэх сан	6.4	2	6.4		-		-	1	-		-		
НИЙТ АЛДАА ЗӨРЧЛИЙН ДҮН		330.2	22	90.2	7	3.6	15	124.4	8	10.2	2	101.9	1	-